



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Чойбалсан сумын цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2026/153/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Дорнод аймаг</p> <p>2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: <a href="mailto:bolortuulb@audit.gov.mn">bolortuulb@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: <a href="mailto:narmandakh@audit.gov.mn">narmandakh@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: <a href="mailto:khaanconsultingaudit@gmail.com">khaanconsultingaudit@gmail.com</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026.02.25 № 194  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН  
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ч.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Чойбалсан сумын цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 24.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1. Нягтлан бодогчтой зэрэгцэн хөдөлмөрийн гэрээ байгуулан үндсэн цалин, бусад холбогдох нэмэгдлүүдийг олгосон.
2. Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг худалдан авсан.

2125020267

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Чойбалсан сумын цэцэрлэг нь 2025 онд 5 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг 76.1 хувиар үнэлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>139,571,700.91</b>	<b>112,945,780.33</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	97,717,376.61	49,683,104.03
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	97,717,376.61	49,683,104.03
31211	Төрийн сангийн харилцах	97,717,376.61	49,683,104.03
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	41,854,324.30	63,262,676.30
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	41,854,324.30	63,262,676.30
35410	Бичиг хэргийн материал	95,300.00	95,300.00
35420	Аж ахуйн материал	37,682,698.50	56,007,870.50
35460	Хүнсний материал	766,300.00	3,145,480.00
35470	Бусад хангамжийн материал	3,310,025.80	4,014,025.80
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>605,588,521.25</b>	<b>622,340,694.77</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	605,588,521.25	622,340,694.77
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	596,988,521.25	613,740,694.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	612,386,504.95	612,386,504.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(116,187,588.30)	(136,629,806.10)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,685,924.50	57,091,017.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,612,103.05)	(13,704,824.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,086,616.00	60,950,866.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,955,812.96)	(19,956,474.02)
39214	Бусад үндсэн хөрөнгө	321,467,131.00	275,751,089.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(242,882,150.89)	(222,147,677.66)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,600,000.00	8,600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,600,000.00	8,600,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>745,160,222.16</b>	<b>735,286,475.10</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>745,160,222.16</b>	<b>735,286,475.10</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	745,160,222.16	735,286,475.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	335,428,484.00	335,428,484.00
51101	Өмч: - төрийн	335,428,484.00	335,428,484.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	184,033,392.54	174,159,645.48
51210	Өмнөх үеийн үр дүн	249,339,402.43	184,033,392.54
51220	Тайлант үеийн үр дүн	(65,306,009.89)	(9,873,747.06)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	225,698,345.62	225,698,345.62
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>745,160,222.16</b>	<b>735,286,475.10</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>530,725,300.00</b>	<b>784,913,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,620,500.00</b>	<b>95,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	13,620,500.00	95,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	13,460,700.00	68,578,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	159,800.00	26,421,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>517,104,800.00</b>	<b>689,913,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	496,260,900.00	663,875,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	496,260,900.00	663,875,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,843,900.00	26,037,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,843,900.00	26,037,600.00

Дорнод аймгийн Чойбалсан сумын цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>596,031,309.89</b>	<b>790,762,414.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>596,031,309.89</b>	<b>790,762,414.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	592,685,903.25	785,318,750.62
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	421,700,655.36	596,945,814.74
210101	Үндсэн цалин	266,318,483.69	354,472,300.03
210102	Нэмэгдэл	141,039,941.42	207,105,778.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,175,000.00
210104	Урамшуулал	14,342,230.25	14,192,736.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,123,871.71	69,779,417.84
210201	Тэтгэврийн даатгал	36,498,016.50	47,454,828.12
210202	Тэтгэмжийн даатгал	4,090,879.47	5,583,297.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,138,241.13	2,835,602.37
210204	Ажилгүйдлийн даатгал	1,999,488.15	2,749,895.07
210205	Эрүүл мэндийн даатгал	8,397,246.46	11,155,794.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,998,493.36	19,093,936.50
210301	Гэрэл, цахилгаан	6,067,733.36	6,476,398.50
210302	Түлш, халаалт	9,930,760.00	12,617,538.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,308,667.00	8,508,528.00
210401	Бичиг хэрэг	-	51,000.00
210408	Бараа материал акалсны зардал	10,308,667.00	8,457,528.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	30,090,125.00	29,033,160.00
210502	Хоол, хүнс	30,090,125.00	29,033,160.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	915,000.00	1,395,000.00
210604	Урсгал засвар	915,000.00	1,395,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	540,000.00	1,253,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	1,253,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	60,009,090.82	59,309,093.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,752,700.00	6,491,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,871,000.00	3,716,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,385,390.82	49,101,393.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,345,406.64	5,443,663.50
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	3,345,406.64	5,443,663.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,345,406.64	5,443,663.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(65,306,009.89)</b>	<b>(5,849,214.12)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	4,024,532.94
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	4,024,532.94
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(4,024,532.94)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(65,306,009.89)</b>	<b>(9,873,747.06)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>517,104,800.00</b>	<b>689,913,200.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>517,104,800.00</b>	<b>689,913,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	496,260,900.00	663,875,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	496,260,900.00	663,875,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,843,900.00	26,037,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,843,900.00	26,037,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>539,835,862.07</b>	<b>737,947,472.58</b>

21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>539,835,862.07</b>	<b>737,947,472.58</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>536,490,445.43</b>	<b>732,503,809.08</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	421,700,655.36	596,945,814.74
210101	Үндсэн цалин	266,318,483.69	354,472,300.03
210102	Нэмэгдэл	141,039,941.42	207,105,778.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,175,000.00
210104	Урамшуулал	14,342,230.25	14,192,736.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,123,871.71	69,779,417.84
210201	Тэтгэврийн даатгал	36,498,016.50	47,454,828.12
210202	Тэтгэмжийн даатгал	4,090,879.47	5,583,297.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,138,241.13	2,835,602.37
210204	Ажилгүйдлийн даатгал	1,999,488.15	2,749,895.07
210205	Эрүүл мэндийн даатгал	8,397,246.46	11,155,794.85
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,998,493.36	19,093,936.50
210301	Гэрэл, цахилгаан	6,067,733.36	6,476,398.50
210302	Түлш, халаалт	9,930,760.00	12,617,538.00
2105	<b>Нормативт зардал</b>	29,605,725.00	31,412,340.00
210502	Хоол, хүнс	29,605,725.00	31,412,340.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	540,000.00	1,253,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	1,253,800.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,021,700.00	12,518,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,027,700.00	8,696,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,994,000.00	3,822,300.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,345,416.64</b>	<b>5,443,663.50</b>
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	3,345,416.64	5,443,663.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,345,416.64	5,443,663.50
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(22,731,062.07)</b>	<b>(48,034,272.58)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(22,731,062.07)	(48,034,272.58)
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	120,448,428.68	97,717,376.61
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	97,717,376.61	49,683,104.03

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	335,428,484.00	225,698,345.62	249,339,402.43	810,466,232.05
Тайлант үеийн үр дүн	-	-	(65,306,009.89)	(65,306,009.89)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,428,484.00	225,698,345.62	184,033,392.54	745,160,222.16

Дорнод аймгийн Чойбалсан сумын цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	335,428,484.00	225,698,345.62	184,033,392.54	745,160,222.16
Тайлант үеийн үр дүн	-	-	(9,873,747.06)	(9,873,747.06)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,428,484.00	225,698,345.62	174,159,645.48	735,286,475.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		97,717,376.61	(97,717,376.61)
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	758,677,900.00	711,909,872.58	46,768,027.42
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	758,677,900.00	711,909,872.58	46,768,027.42
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	758,677,900.00	711,909,872.58	46,768,027.42
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	617,164,900.00	596,945,814.74	20,219,085.26
210101	Үндсэн цалин	374,345,600.00	354,472,300.03	19,873,299.97
210102	Нэмэгдэл	229,611,500.00	207,105,778.71	22,505,721.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт		21,175,000.00	(21,175,000.00)
210104	Урамшуулал	13,207,800.00	14,192,736.00	(984,936.00)
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	76,721,300.00	69,779,417.84	6,941,882.16
210201	Тэтгэврийн даатгал	52,034,700.00	47,454,828.12	4,579,871.88
210202	Тэтгэмжийн даатгал	6,171,700.00	5,583,297.43	588,402.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,085,800.00	2,835,602.37	250,197.63
210204	Ажилгүйдлийн даатгал	3,085,800.00	2,749,895.07	335,904.93
210205	Эрүүл мэндийн даатгал	12,343,300.00	11,155,794.85	1,187,505.15
2105	<b>Нормативд зардал</b>	40,981,900.00	31,412,340.00	9,569,560.00
210502	Хоол хүнс	40,981,900.00	31,412,340.00	9,569,560.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,234,100.00	1,253,800.00	980,300.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	2,234,100.00	1,253,800.00	980,300.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,575,700.00	12,518,500.00	9,057,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,753,100.00	8,696,200.00	9,056,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,822,600.00	3,822,300.00	300.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	758,677,900.00	663,875,600.00	94,802,300.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	670,599,900.00	663,875,600.00	6,724,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	670,599,900.00	663,875,600.00	6,724,300.00
	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	88,078,000.00	-	88,078,000.00
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	88,078,000.00	-	88,078,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	97,717,376.61	(97,717,376.61)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	49,683,104.03	(49,683,104.03)

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>26,037,600.00</b>	<b>20,593,936.50</b>	-
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>26,037,600.00</b>	<b>20,593,936.50</b>	-
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>26,037,600.00</b>	<b>20,593,936.50</b>	<b>5,443,663.50</b>
2103	<b>БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ</b>	<b>24,537,600.00</b>	<b>19,093,936.50</b>	<b>5,443,663.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,837,600.00	6,476,398.50	<b>5,361,201.50</b>
21302	Түлш халаалт	12,700,000.00	12,617,538.00	<b>82,462.00</b>
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	<b>0.00</b>

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24.9 сая төгрөгийн зөрчилд<sup>1</sup> 2 албан шаардлага хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 24.9 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13.1 сая төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

### 3.1 Албан шаардлага

- Нягтлан бодогч зэрэгцэн хөдөлмөрийн гэрээгээр үндсэн цалинг 100%, бусад холбогдох нэмэгдлүүдийг тооцоолон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно", 57 дугаар зүйлийн 57.3-т "Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина", 84 дүгээр зүйлийн 84.4-т "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг тайлант хугацаанд гүйцэтгэлээр худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих гэж

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нягтлан бодогч зэрэгцэн хөдөлмөрийн гэрээгээр үндсэн цалинг 100%, бусад холбогдох нэмэгдлүүдийг тооцоолон олгосон	1	24,406.1			1	24,406.1						
Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг тайлант хугацаанд гүйцэтгэлээр худалдан авсан	1	535.2			1	535.2						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>24,941.3</b>			<b>2</b>	<b>24,941.3</b>						